

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны ... дугаар  
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

## Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 01/318 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын санал, “Даланзадгадын дулаан хангамжийн газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 71 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Д.Эрдэнэтөгс), “Даланзадгадын дулаан хангамжийн газар” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал (Б.Мөнх-Амар) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Болор-Эрдэнэ/-д даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 125 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД СУМЫН  
АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

1. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:  
Үүнд:

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Орон сууцны халаалт (оюутны байр, зоорийн давхар, хонгил, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м <sup>2</sup>	800.0	
2	Ахуйн хэрэгцээний ус халаасан дулаан	Халаалтын улиралд	Төг/хүн	1,870.0
		Халаалтын бус улиралд	Төг/хүн	2,806.0
3	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,300.0
		41-81 м <sup>2</sup> талбайтай айл өрх	Төг/сар	5,500.0
		81 м <sup>2</sup> –с дээш талбайтай айл өрх	Төг/сар	11,000.0